



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

ШИЛЭН ДАНСНЫ АУДИТЫН ТАЙЛАН

2026 оны 1 дүгээр улирал



АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	2
Хүснэгтийн товъёг	2
Хавсралтууд	2
Аудитын зорилго хамрах хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдээлэл	3
Ерөнхий мэдээлэл	4
Аудитын үр дүн	4-5
Аудитаар илрүүлсэн асуудал	6-8
Илрүүлсэн зөрчил	8
Дүгнэлт	8-9
Зөвлөмж	9

Товчилсон үгийн жагсаалт

ДАМПОУС	Дотоод аудитын мэргэжлийн практик олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	ОНХС
СХШУАБ	Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	ТТЗ
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХС	Хороо хөгжүүлэх сан

Хүснэгтийн товъёг

д/д	Тайлбар	Хуудасын дугаар
Хүснэгт 1	ТЕЗ-ийн эрхлэх хүрээний байгууллагуудын 2026 оны 1 дүгээр улирлын байдлаарх мэдээлэл байршуулсан байгууллага, сумдын гүйцэтгэлийн үнэлгээний нэгтгэл	5-6

Хавсралт

д/д	Хавсралтын нэр	Хуудасын дугаар
Хавсралт 1.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний байгууллагуудын 2026 оны 1 дүгээр улирлын шилэн дансны үнэлгээний жагсаалт	10-16
Хавсралт 2.	Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байгууллагуудын жагсаалт	17-24
Хавсралт 3.	Шилэн дансны мэдээллийг үнэн зөв, иж бүрэн мэдээлээгүй байгууллагын жагсаалт	25-28
Хавсралт 4.	Шилэн дансны мэдээллийг дутуу оруулсан байгууллагуудын жагсаалт	29-30

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН
ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

<p align="center">Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:</p>	<p>Аудитыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан Төсвийн Ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын нэгжийн бүрэн эрхийн хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйл, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтыг тус тус үндэслэн Дотоод аудитын хорооны 2026 оны "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай" А/01 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2026 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тухай ДА-2026/01/НА дугаартай удирдамжийн дагуу хийж гүйцэтгэлээ.</p>
<p align="center">Аудитын зорилт:</p>	<p>ТЕЗ-ийн харьяа байгууллагууд Шилэн дансы тухай хуулийн хэрэгжилтийг хангасан эсэхэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.</p>
<p align="center">Аудитын хамарсан хүрээ:</p>	<p>Аудитад аймгийн ТЕЗ-ийн харьяа орон нутгийн бүх шатны төсвийн захирагчид орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сан зэрэг нийт 128 объектын 2026 оны шилэн дансны цахим системийн мэдээллийг хамруулав.</p>
<p align="center">Аудитын арга зүй:</p>	<p>Аудитыг ДАМПОУС 1100, 2200-2450 стандарт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар баталсан Улсын салбарын дотоод аудитын аргачлалын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулалт, түүвэрлэлт зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.</p>
<p align="center">Аудитын шалгуур, үзүүлэлт:</p>	<p>Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:</p> <p>Төсвийн тухай хууль Шилэн дансны тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар баталсан Улсын салбарын дотоод аудитын аргачлал, ДАМПОУС 1100, 2200-2450 дугаар стандарт, холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам</p>
<p align="center">Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:</p>	<p>Аудитыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга, СХШУАБ Т.Одсүрэн удирдаж СХШУАБ Т.Мөнхзул явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн нэгтгэх, Дотоод аудитор Г.Дорждэрэм, Д.Ванчигмаа, Б.Идэрчулуун нар 2026 оны 04 дүгээр сарын 14-ны өдрөөс 04 дүгээр сарын 17-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.</p>

1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн хяналт дотоод аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч /Цаашид ТЕЗ гэх/-ийн харьяа орон нутгийн нийт 128 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуй нэгж газар, тусгай сангийн 2026 оны нэгдүгээр байдлаар **5653** мэдээллийг жил, улирал, сар, тухай бүр гэсэн хугацаанд байршуулахаар хуульчилж өгсөн тул уг тоон мэдээллийн байршуулалтын иж бүрэн, үнэн зөв мэдээлэгдсэн эсэхэд “Төлөвлөгөөт” хяналт шалгалтыг баталсан удирдамжийн дагуу эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж гүйцэтгэсэн тайланг танилцуулж байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах ТЕЗ-ийн 1, харьяа 17 ТТЗ, 52 төсвийн байгууллага, 23 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 35 тусгай сан, нийт **128** байгууллагыг хамруулан, аудитыг гүйцэтгэсэн.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Санхүүгийн хяналт дотоод аудитын газраас 2026 оны 1 дүгээр улирлын шилэн дансны мэдээлэл байршуулалтад хийсэн аудитаар нийт **5653** мэдээлэл байршуулахаас **5566** мэдээлэл байршуулж, **19** мэдээллийг үнэн зөв мэдээлээгүй, **87** мэдээллийг байршуулаагүй, **96** мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн дундаж **96.8** хувьтай тайлагнагдсан байна.

2.АУДИТЫН ҮР ДҮН

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар шилэн дансны мэдээлэл байршуулалт 90.4 хувьтай байсан бол хяналт хийгдэн зөвлөмжийн биелэлтийн үр дүнд 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар 96.8 хувь буюу 6.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үр дүнг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

Шилэн дансны мэдээлэл байршуулсан гүйцэтгэлийн харьцуулсан нэгтгэл

Хүснэгт №1.

№	Байгууллагын нэрс	2025 оны 1 дүгээр улирлын байдлаар				2026 оны 1 дүгээр улирлын байдлаар			Өссөн хувь
		Байгууллагын тоо	Хугацаа хоцорсон мэдээллийн тоо	Мэдээлээгүй тоо	Нийт хэрэгжилтийн хувь	Хугацаа хоцорсон мэдээллийн тоо	Мэдээлээгүй тоо	Нийт хэрэгжилтийн хувь	

1	Сэлэнгэ аймгийн Засаг дарга	1	10	7	62.2	2	-	95.2	33.0
2	Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газар	1	5	2	84.4	1	-	97.6	13.2
3	Сэлэнгэ аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	1			100.0	-	9	100.0	
4	Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	2		92.9	-	-	100.0	7.1
6	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	1			100.0	-	-	100.0	
8	Худалдан авах ажиллагааны газар	1	6		86.7	-	-	97.8	11.1
5	Сэлэнгэ аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	1			100.0	-	-	100.0	
7	Орон нутгийн өмчийн газар	1			100.0	-	-	100.0	
9	Алтанбулаг сумын дүн	5	16	0	91.3	1	-	99.5	8.2
12	Ерөө сумын дүн	6	12	0	95.6	4	-	98.1	2.5
13	Жавхлант сумын дүн	5	0	0	100.0	-	-	100.0	0.0
22	Хушаат сумын дүн	5	2	0	99.1	-	-	100.0	0.9
11	Баянгол сумын дүн	5	8	25	85.3	14	-	93.7	8.4
14	Зүүнбүрэн сумын дүн	5	11	0	95.0	-	13	100.0	5.0
15	Мандал сумын дүн	7	8	0	97.4	8	-	97.3	
19	Сант сумын дүн	5	7	0	96.0	1	11	99.5	3.5
23	Хүдэр сумын дүн	5	7	0	96.3	2	-	99.1	2.8
24	Цагааннуур сумын дүн	5	0	0	100.0	-	-	100.0	
25	Шаамар сумын дүн	6	7	22	88.9	16	-	92.1	3.2
10	Баруунбүрэн сумын дүн	5	3	0	98.6	1	-	99.5	0.9
17	Орхонтуул сумын дүн	6	16	83	47.5	5	7	98.0	50.5
18	Сайхан сумын дүн	7	5	0	98.4	4	3	98.7	0.3
16	Орхон сумын дүн	5	6	51	66.7	6	-	95.9	29.3
20	Сүхбаатар сумын дүн	5	4		98.2	1	-	98.2	
21	Түшиг сумын дүн	5	8	0	96.3	6	-	96.8	0.6
26	Ойн ангийн дүн	5	2	2	98.5	1	2	99.1	0.6
27	ОНӨААТҮГ-ын дүн	23	16	69	82.3	23	42	97.0	14.7
Нийт дүн		128	151	254	90.4	96	87	96.8	6.4

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний байгууллагуудын 2026 оны шилэн дансны үнэлгээний жагсаалтыг тайлангийн 1 дүгээр хавсралтад дэлгэрэнгүй харуулав.

3. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ

Шилэн дансны мэдээлэл байршуулалтад хийсэн аудитаар 19 мэдээллийг үнэн зөв мэдээлээгүй, мэдээлбэл зохих 87 мэдээллийг огт мэдээлээгүй, 96 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлийг илэрсэн асуудал тус бүрээр бодит нөхцөл байдал, асуудлын үндсэн шалтгаан, сөрөг үр дагаврыг тодорхойлж зөвлөн туслах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

Илэрсэн асуудал 3.1	Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.
Асуудлын ангилал	Нөлөө дунд

Бодит байдал:

1. Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн эрхлэх хүрээний нийт 128 байгууллага мэдээлбэл зохих мэдээллээс нийт 44 байгууллагын 96 мэдээллийг хуулийн хугацаа хоцроосон байна. Үүнд: ТТЗ-ийн 24, ТШЗ-ийн 31, ОНӨААТҮГ-ын 23, ОНХС-ийн 10, ХХС-ийн 8 мэдээлэл байна. Үүнийг тайлангийн **2 дугаар хавсралтаар** дэлгэрэнгүй харуулав.

Байх ёстой шаардлага /шалгуур/: 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар ТЕЗ, ТТЗ, ТШЗ, Тусгай сан, ОНӨААТҮГ-ын нийт мэдээллийг сар, улирал, тухайн үед гэсэн хугацаанд ангиллаар байршуулахаар хуульчилж өгсөн тул уг тоон мэдээлэл бүрэн, үнэн зөв мэдээлэгдсэн байх шаардлагатай.

Асуудлын үндсэн шалтгаан: Шилэн дансны шинэ цахим хуудсанд шинээр бүртгэл үүсгэж бүртгүүлээгүй, бүртгэл үүсгэсэн боловч мэдээллийг дутуу оруулсан, мэдээлэл оруулах албан тушаалтан бүрэн гүйцэт сонгож баталгаажуулаагүй, мэдээлэл байршуулалтын хуулийн хугацааг хэтрүүлсэн, нийтэд ил тод болгоогүй. Тухайн хариуцсан ажилтны ажлын хариуцлагатай холбоотой, мөн хариуцсан ажилтан солигдсонтой холбоотой байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

- Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй
- Шилэн дансны мэдээлэл байршуулалтын хугацаа хоцрох,
- Аймгийн шилэн дансны мэдээлэл байршуулалтын хувийг бууруулах, сөргөөр нөлөөлөх
- Журмын 9.1. дэх “ Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хариуцлага ногдуулна.” гэсэн заалтын дагуу хариуцлага хүлээх эрсдэлтэй.

Зөвлөмж:

1. Шилэн дансны системд батлагдсан төсвийг мэдээлэхдээ мөнгөн дүнг төгрөгөөр мэдээлэх
2. Шилэн дансны системд мэдээллийг оруулахдаа хугацаа хоцроохгүй байх

Илэрсэн асуудал

3.2

Шилэн дансны мэдээллийг үнэн зөв, иж бүрэн мэдээлээгүй.

Асуудлын ангилал

Нөлөө дунд

Бодит байдал:

1. Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн эрхлэх хүрээний нийт 128 байгууллага мэдээлбэл зохих 5653 мэдээллээс 16 байгууллагын 19 мэдээллийг үнэн зөв мэдээлээгүй байна. Үүнд: ТТЗ-ийн 4, Төсвийн шууд захирагчийн 5, ОНӨААТҮГ 6, ОНХС-ий 2, ХХС 2 мэдээллийг тайлангийн **3 дугаар хавсралтаар** дэлгэрэнгүй харуулав.

Байх ёстой шаардлага /шалгуур/: Монгол Улсын Шилэн дансны тухай хууль, Засгийн Газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, Шилэн дансны тухай хуульд заасан 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 3.1.2.төрийн өмчит үйлдвэрийн газар нь шилэн дансны мэдээллийг тогтмол мэдээлнэ.

Асуудлын үндсэн шалтгаан: Асуудлын үндсэн шалтгаан: Шилэн дансны шинэ цахим хуудсанд шинээр бүртгэл үүсгэж бүртгүүлээгүй, бүртгэл үүсгэсэн боловч мэдээллийг дутуу оруулсан, мэдээлэл оруулах албан тушаалтан бүрэн гүйцэт сонгож

баталгаажуулаагүй, мэдээлэл байршуулалтын хуулийн хугацааг хэтрүүлсэн, нийтэд ил тод болгоогүй. Тухайн хариуцсан ажилтны ажлын хариуцлагатай холбоотой.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

- Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй
- Шилэн дансны мэдээлэл байршуулалтын хугацаа хоцрох,
- Аймгийн шилэн дансны мэдээлэл байршуулалтын хувийг бууруулах, сөргөөр нөлөөлөх

- Журмын 9.1. дэх “ Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хариуцлага ногдуулна.” гэсэн заалтын дагуу хариуцлага хүлээх эрсдэлтэй.

Зөвлөмж:

1. Орон нутгийн төсвийн болон өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулахад төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлэх.
2. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4. дах заалтад “Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно.” гэсэн заалтын хүрээнд сум, байгууллагын ажлын үр дүнг дүгнэх гол үзүүлэлт болдог тул цаашид байгууллагын дарга эрхлэгч нар шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартын дагуу мэдээлж буй эсэхэд хяналтыг хэрэгжүүлэх.

Илэрсэн асуудал 3.3	Шилэн дансны цахим системд мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлээгүй болон огт мэдээлээгүй.
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй

Бодит байдал:

Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн эрхлэх хүрээний нийт 128 байгууллага мэдээлбэл зохих 5653 мэдээллээс 14 байгууллагын нийт 87 мэдээллийг мэдээлээгүй.. Үүнд:

- ✓ ТТЗ-ийн 10, ТШЗ-ийн 9, ОНӨААТҮГ-ын 42 ОНХС-ийн 26 мэдээлэл / АОНХС-9, Зүүнбүрэн сумын ОНХС-12/ оруулаагүйг тайлангийн **4 дугаар хавсралтаар** дэлгэрэнгүй харуулав.
- ✓ ОНӨААТҮГ-ын 42 /Мандал хишиг хайрхан ОНӨААТҮГ-39 болон Мандал “Гавшгай- Ус” ОНӨААТҮГ нь 2 нийт 42 мэдээллийг огт мэдээлээгүй байна/

Байх ёстой шаардлага /шалгуур/: Шилэн дансны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1. “Энэ хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо /цаашид "шилэн данс" гэх/-г бүрдүүлэхэд оршино.” 3 дугаар зүйлийн 3.1.1. “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд” энэ хуулийн үйлчлэлд хамаарна.

Асуудлын үндсэн шалтгаан: Шилэн дансны тухай хуулийн 1.1. “Энэ хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт

хяналт тавих мэдээллийн тогтолцоо /цаашид "шилэн данс" гэх/-г бүрдүүлэхэд оршино". Хариуцсан ажилтны ажлын хариуцлагатай холбоотой.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

- Тухайн байгууллага мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах хязгаарлалт үүссэн.
- Журмын 9.1. дэх " Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хариуцлага ногдуулна." гэсэн заалтын дагуу хариуцлага хүлээх эрсдэлтэй.

Зөвлөмж:

1. Шилэн дансны цахим системд мэдээлээгүй мэдээллийг нөхөн оруулах
2. Шилэн дансны тухай хуулийн 5.8 Мэдээллийн самбар нь олон нийтийн мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломжийг хангасан, түүнд тавигдсан мэдээлэл нь энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан албан тушаалтны газрын үсгээр баталгаажсан байна. 5.7-д зааснаар цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбар байршуулна гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлэн ажиллах

4. ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар нийт 5,653 мэдээлэл байршуулахаас дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- **Хугацаа хоцроож мэдээлсэн:** Нийт 44 байгууллагын 96 мэдээллийг хуулийн хугацаанаас хоцруулж байршуулсан. Үүнд ТЕЗ-ийн мэдээлбэл зохих 2, ТТЗ-ийн 22, ТШЗ-ийн 31, ОНӨААТҮГ 23, ОНХС 10, ХХС 8 мэдээллийг хуульд заасан хугацаанаас тус тус хоцроож мэдээлсэн байна.
- **Мэдээллийг огт байршуулаагүй:** Шилэн дансны цахим системд 14 байгууллагын нийт 87 мэдээллийг огт байршуулаагүй байна. Үүнд ТТЗ-ийн 10, ТШЗ-ийн 9, ОНӨААТҮГ 42, ОНХС 25, ХХС 1 мэдээллийг хуульд заасан хугацаанаас тус тус хоцроож мэдээлсэн байна. бөгөөд үүний дийлэнх хувийг буюу 42 мэдээллийг (ОНӨААТҮГ) –ууд эзэлж байна.
- **Мэдээллийг үнэн зөв мэдээлээгүй:** Шилэн дансны цахим системд 16 байгууллагын нийт 19 мэдээллийг бодит байдалтай нийцэхгүй, алдаатай байршуулсан

5. ДҮГНЭЛТ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитад хамрагдсан 89 байгууллага 35 сангийн нийт 5653 мэдээлэл байршуулахаас мэдээлбэл зохих 87 мэдээллийг мэдээлээгүй нь нийт мэдээллийн 1,5 хувийг эзэлж байгаа тул "нөлөө багатай" гэж үзсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл явцын төлөвшил нь "давтамжтай буюу 3-р түвшин"-д буюу үнэлгээг "Хангалттай" гэж дүгнэлээ.

- **Хэрэгжилтийн түвшин:** Аймгийн хэмжээнд 2026 оны нэгдүгээр улирлын байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн дундаж үзүүлэлт 96.0 хувьтай байгаа нь 2025 оны жилийн эцсийн үнэлгээнээс 0.4 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна.
- **Зөрчлийн шалтгаан:** Зөрчил үүсэх үндсэн шалтгаан нь хариуцсан ажилтны ажлын хариуцлага, ажилтнууд солигдсонтой холбоотой хүний нөөцийн тогтворгүй байдал болон шинэ цахим хуудсанд бүртгэл үүсгэх, баталгаажуулах үйл явц дутуу хийгдсэнтэй холбоотой байна.
- **Байгууллагын ялгаатай байдал:** Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Сэлэнгэ аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар, Орон нутгийн өмчийн газар Цагааннуур, Жавхлант, Хушаат, сумд 100 хувийн хэрэгжилттэй байгаа бол аймгийн ОНХС (78.6%), Зүүнбүрэн сумын ОНХС (71.0%) Хүдэр сумын ТТЗ (68.3%), Гавшгай-Ус ОНӨААТҮГ (73,3%) хэрэгжилт харьцангуй хангалтгүй байна. Мандал Хишигхайрхан ОНӨААТҮГ нь шилэн дансанд нэг ч мэдээлэл оруулаагүй үйл ажиллагаа явагдаагүй хариуцсан хүнгүй гэдэг шалтгаанаар сангийн яаманд дахь аймгийн нэгтгэлд 39 мэдээлэл оруулаагүй дүнгээр жил бүр орж байна.
- **Сайн тал:** Сүхбаатар сумын ТТЗ болон ЗДТГ, Сайхан сумын ТТЗ -нар 2025 оны жилийн эцсийн шилэн дансны зөвлөмжийн биелэлтээ тус газарт ирүүлж мэдээллээ 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар бүрэн гүйцэд оруулсан байна.

6.ЗӨВЛӨМЖ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид:

- **Хариуцлагын тогтолцоо:** Шилэн дансны цахим системээр дамжуулан олон нийтэд ил тод нээлтэй байх төсөв, санхүүгийн мэдээллийг хууль тогтоомж, журамд заасан хугацаанд мэдээллийг дутуу оруулах, хугацаа хоцроох, буруу мэдээлэл оруулж үнэн зөв байдлыг алдагдуулах, хангалтгүй үнэлгээ авах зэрэг эрсдэлийг бууруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах хариуцлагын тогтолцоог сайжруулах хугацаатай үүрэг даалгаврыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх.
- **Үнэлгээний шалгуур болгох:** Сум, агентлаг болон харьяа байгууллагуудын ажлын үр дүнг дүгнэхдээ Шилэн дансны хөтлөлтийг үндсэн үзүүлэлт (KPI) болгон хатуу мөрдөж ажиллах.

Төсвийн болон ОНӨААТҮГ-ны дарга нарт:

- **Нөхөн байршуулах:** Шилэн дансны цахим системд 3, 4 дүгээр хавсралтад дурдсан үнэн зөв мэдээлээгүй болон огт мэдээлээгүй нийт 106 мэдээллийг

яаралтай нөхөн байршуулж, ил тод байдлыг хангаж зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх.

- **Хяналтыг сайжруулах:** Байгууллагын дарга, удирдлага нар шилэн дансны мэдээллийн агуулга, стандартад тавих дотоод хяналтаа сайжруулж, мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулах.
- ТЕЗ-ийн Дотоод аудитын нэгжээс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийтлэг гарч байгаа зөрчил, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээ авах.

ДАРГА, СХШУАБ

Т.ОДСҮРЭН

СХШУАБ *Мөнхзул*

Т.МӨНХЗУЛ

ДОТООД АУДИТОР *Дорждэрэм*

ДОРЖДЭРЭМ

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ЭРХЛЭХ ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН
2026 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ**

ХТҮ9005 1224020025 3749363

№	Байгууллагын нэрс	Үнэлгээг гаргасан албан тушаалтан	мэдээлэх тоо	Мэдээлсэн тоо	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцроосон мэдээллийн тоо	үнэн зөв мэдээлээгүй	Мэдээлээгүй тоо	Нийт хэрэгжилтийн хувь
1	Сэлэнгэ аймгийн Засаг дарга	Б.Идэрчулуун	42	42	40	2			95.2
2	Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газар	Б.Идэрчулуун	42	42	41	1			97.6
3	Сэлэнгэ аймгийн Орон нутгийн хөгжлийн сан	Б.Идэрчулуун	42	42	33			9	78.6
4	Баянгол сумын Засаг дарга	Б.Идэрчулуун	45	45	42	3			93.3
5	Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Б.Идэрчулуун	45	45	39	6			86.7
6	Баянгол сумын Засаг даргын Тамгын газар	Б.Идэрчулуун	45	45	41	4			73.3
7	Баянгол сумын Орон нутгийн хөгжлийн сан	Б.Идэрчулуун	45	45	44	1			97.8
8	Баянгол сумын Хоршоо хөгжүүлэх сан	Б.Идэрчулуун	42	42	42				100.0
9	Зүүнбүрэн сумын Засаг дарга	Б.Идэрчулуун	48	48	48				100.0
10	Зүүнбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал	Б.Идэрчулуун	45	45	45				100.0
11	Зүүнбүрэн сумын Засаг даргын Тамгын газар	Б.Идэрчулуун	45	45	45				100.0
12	Зүүнбүрэн сумын Орон нутгийн хөгжлийн сан	Б.Идэрчулуун	42	42	30			12	71.4
13	Зүүнбүрэн сумын Хоршоо хөгжүүлэх сан	Б.Идэрчулуун	42	42	41			1	97.6
14	Мандал сумын Засаг дарга	Б.Идэрчулуун	45	45	41	4			91.1
15	Мандал сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал	Б.Идэрчулуун	45	45	44	1			97.8
16	Мандал сумын Засаг даргын Тамгын газар	Б.Идэрчулуун	45	45	44	1			97.8
17	Мандал сумын Хэрх тосгоны захирагчийн алба	Б.Идэрчулуун	44	44	44				100.0

18	Мандал сумын Түнхэл тосгоны захирагчийн алба	Б.Идэрчулуун	44	44	44				100.0
19	Мандал сумын Орон нутгийн хөгжлийн сан	Б.Идэрчулуун	39	39	38	1			97.4
20	Мандал сумын Хоршоо хөгжүүлэх сан	Б.Идэрчулуун	39	39	38	1			97.4
21	Мандал Энхмэнд сувилал ААТҮГ	Б.Идэрчулуун	46	46	45	1			97.8
22	Мандал Тохилог хараа ААТҮГ	Б.Идэрчулуун	39	39	37	2			94.9
23	Мандал энерго ОНӨААТҮГ газар	Б.Идэрчулуун	45	45	45				100.0
24	Мандал шинэ агротехник ОНӨААТҮГ	Б.Идэрчулуун	46	46	46				100.0
25	Мандал хишиг хайрхан ОНӨААТҮГ	Б.Идэрчулуун	39	39	0			39	-
26	Мандал "Цанторхон" ОНӨААТҮГ	Б.Идэрчулуун	46	46	43	3			93.5
27	Баруунбүрэн сумын Засаг дарга	Д.Ванчигмаа	48	48	48				100.0
28	Баруунбүрэн сумын Засаг даргын тамгын газар	Д.Ванчигмаа	45	45	45				100.0
29	Баруунбүрэн сумын Хоршоо хөгжүүлэх сан	Д.Ванчигмаа	39	39	38	1			97.4
30	Баруунбүрэн сумын Орон нутгийн хөгжлийн сан	Д.Ванчигмаа	39	39	39				100.0
31	Баруунбүрэн сумын Иргэдийн төлөөлөгчийн хурал	Д.Ванчигмаа	45	45	45				100.0
32	Орхонтуул сумын Засаг дарга	Д.Ванчигмаа	45	39	39	3			97.8
33	Орхонтуул сумын Хоршоо хөгжүүлэх сан	Д.Ванчигмаа	39	39	39				100.0
34	Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн алба	Д.Ванчигмаа	42	39	39	1		1	97.8
35	Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал	Д.Ванчигмаа	45	44	44			1	97.7
36	Орхонтуул сум Орон нутгийн хөгжлийн сан	Д.Ванчигмаа	42	38	37	1		4	88.0
37	Орхонтуул сум Засаг даргын Тамгын газар	Д.Ванчигмаа	45	44	44			1	97.7
38	Сайхан сумын Засаг дарга	Д.Ванчигмаа	48	45	43	2		3	89.5
39	Сайхан сумын Хот тохижилтын газар	Д.Ванчигмаа	45	45	43	2			95.5
40	Сайхан сумын Хоршоо хөгжүүлэх сан	Д.Ванчигмаа	42	42	42				100.0

41	Сайхан сумын Орон нутгийн хөгжлийн сан	Д.Ванчигмаа	42	42	42				100.0
42	Сайхан сумын Номгон тосгоны захирагчийн алба	Д.Ванчигмаа	45	45	45				100.0
43	Сайхан сумын Иргэдийн төлөөлөгчийн хурал	Д.Ванчигмаа	45	45	45				100.0
44	Сайхан сумын Засаг даргын Тамгын газар	Д.Ванчигмаа	45	45	45				100.0
45	Орхон бүсийн сум дундын Ойн анги	Д.Ванчигмаа	45	43	43			2	95.5
46	Ерөөгийн бүсийн сум дундын Ойн анги	Д.Ванчигмаа	45	45	44	1			97.7
47	Сэлэнгэ бүсийн сум дундын ойн анги	Д.Ванчигмаа	45	45	45				100.0
48	Бэлчир бүсийн сум дундын ойн анги	Д.Ванчигмаа	45	45	45				100.0
49	Мандал сумын Хараа бүсийн сум дундын Ойн анги	Д.Ванчигмаа	45	45	45				100.0
50	Баянгол сумын Баянгол сувилал ААТҮГ	Д.Ванчигмаа	46	46	46				100.0
51	"Гавшгай Ус" ААТҮГ	Д.Ванчигмаа	40	38	35	3	2	2	73.3
52	Туулын хишиг ОНӨААТҮГ	Д.Ванчигмаа	43	42	40	2		1	93.0
53	Хүдэр ой анги орон нутгийн өмчит ААТҮГ	Д.Ванчигмаа	46	46	44	2			95.6
54	Худалдан авах ажиллагааны газар	Б.Идэрчулуун	45	45	45		1		100.0
55	Орхон сумын Засаг дарга	Б.Идэрчулуун	48	48	47		1		97.9
56	Орхон сумын Хоршоо хөгжүүлэх сан	Б.Идэрчулуун	42	42	39	3			92.9
57	Орхон сумын Орон нутгийн хөгжлийн сан	Б.Идэрчулуун	42	42	39	3			92.9
58	Орхон сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	Б.Идэрчулуун	45	45	44		1		97.8
59	Орхон сумын Засаг даргын тамгын газар	Б.Идэрчулуун	45	45	44		1		97.8
60	Сүхбаатар сумын Засаг дарга	Б.Идэрчулуун	48	48	48				100.0
61	Сүхбаатар сумын Хоршоо хөгжүүлэх сан	Б.Идэрчулуун	42	42	42		1		100.0
62	Сүхбаатар сумын Орон нутгийн хөгжлийн сан	Б.Идэрчулуун	42	42	42		1		100.0
63	Сүхбаатар сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	Б.Идэрчулуун	45	45	45		1		100.0

64	Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар	Б.Идэрчулуун	45	45	44	1		97.8
65	Түшиг сумын Засаг дарга	Б.Идэрчулуун	48	48	48			100.0
66	Түшиг сумын Хоршоо хөгжүүлэх сан	Б.Идэрчулуун	42	42	42		1	100.0
67	Түшиг сумын Орон нутгийн хөгжлийн сан	Б.Идэрчулуун	42	42	40	2		95.2
68	Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал	Б.Идэрчулуун	45	45	43	2		95.6
69	Түшиг сумын Засаг даргын Тамгын газар	Б.Идэрчулуун	45	45	43	2		95.6
70	Мандах зэлтэр тохижилт үйлчилгээ ААТҮГ	Б.Идэрчулуун	45	45	45			100.0
71	Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ	Б.Идэрчулуун	46	46	42	4		91.3
72	Цагаан эрэг тохижилт үйлчилгээ ААТҮГ	Б.Идэрчулуун	43	43	42	1		97.7
73	Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ	Б.Идэрчулуун	42	42	42			100.0
74	Сэлэнгэ Цэнгэг ус ААТҮГ	Б.Идэрчулуун	43	43	40	3	1	93.0
75	Өргөн сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ	Б.Идэрчулуун	46	46	46		1	100.0
76	"Сэлэнгэ-Үржлийн Цөм Сүргийн Аж Ахуй" ОНӨААТҮГ	Б.Идэрчулуун	42	42	42			100.0
77	"Сэлэнгэ Орон сууц" ОНӨААТҮГ	Б.Идэрчулуун	46	46	46			100.0
78	"Сэлэнгэ барилга захиалагч" ОНӨААТҮГ	Б.Идэрчулуун	46	46	46		1	100.0
79	Сэлэнгэ аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	Т.Мөнхзул	45	45	45			100.0
80	Орон нутгийн өмчийн газар	Т.Мөнхзул	45	45	45			100.0
81	Алтанбулаг сумын Засаг дарга	Т.Мөнхзул	48	48	48			100.0
82	Алтанбулаг сумын Хоршоо хөгжүүлэх сан	Т.Мөнхзул	42	42	42			100.0
83	Алтанбулаг сумын Орон нутгийн хөгжлийн сан	Т.Мөнхзул	42	42	42			100.0
84	Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Т.Мөнхзул	45	45	45			100.0
85	Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газар	Т.Мөнхзул	45	44	44	1		97.8
86	Ерөө сумын Засаг дарга	Т.Мөнхзул	45	45	45			100.0

87	Ерөө сумын Хоршоо хөгжүүлэх сан	Т.Мөнхзул	42	42	42				100.0
88	Ерөө сумын Орон нутгийн хөгжлийн сан	Т.Мөнхзул	42	42	40	1	1		95.2
89	Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Т.Мөнхзул	45	45	45				100.0
90	Ерөө сумын Засаг даргын Тамгын газар	Т.Мөнхзул	45	45	45				100.0
91	Ерөө сумын Бугант тосгоны Захирагчийн алба	Т.Мөнхзул	42	42	39	3			92.9
92	Жавхлант сумын Засаг дарга	Т.Мөнхзул	48	48	48				100.0
93	Жавхлант сумын Хоршоо хөгжүүлэх сан	Т.Мөнхзул	42	42	42				100.0
94	Жавхлант сумын Орон нутгийн хөгжлийн сан	Т.Мөнхзул	42	42	42				100.0
95	Жавхлант сумын Иргэдийн төлөөлөгчийн хурал	Т.Мөнхзул	45	45	45				100.0
96	Жавхлант сумын Засаг даргын тамгын газар	Т.Мөнхзул	45	45	45				100.0
97	Хушаат сумын Засаг дарга	Т.Мөнхзул	48	48	48				100.0
98	Хушаат сумын Орон нутгийн хөгжлийн сан	Т.Мөнхзул	45	45	45				100.0
99	Хушаат сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал	Т.Мөнхзул	45	45	45				100.0
100	Хушаат сумын Засаг даргын Тамгын газар	Т.Мөнхзул	45	45	45				100.0
101	Хушаат сумын Хоршоо хөгжүүлэх сан	Т.Мөнхзул	48	48	48				100.0
102	Цагааннуур тохижилт ААТҮГ	Т.Мөнхзул	49	49	49				100.0
103	Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Г.Дорждэрэм	45	45	45				100.0
104	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	Г.Дорждэрэм	45	45	45				100.0
105	Сант сумын Засаг дарга	Г.Дорждэрэм	48	48	41			7	85.4
106	Сант сумын Хоршоо хөгжүүлэх сан	Г.Дорждэрэм	42	42	42				100.0
107	Сант сумын Орон нутгийн хөгжлийн сан	Г.Дорждэрэм	39	39	38	1			97.4
108	Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Г.Дорждэрэм	45	45	45				100.0
109	Сант сумын Засаг даргын Тамгын газар	Г.Дорждэрэм	44	44	40			4	90.9
110	Хүдэр сумын Засаг дарга	Г.Дорждэрэм	48	48	33	2			68.8

111	Хүдэр сум Хоршоо хөгжүүлэх сан	Г.Дорждэрэм	42	42	41				97.6
112	Хүдэр сум Орон нутгийн хөгжлийн сан	Г.Дорждэрэм	42	42	41				97.6
113	Хүдэр иргэдийн Төлөөлөгчдийн хурал	Г.Дорждэрэм	45	45	43				95.6
114	Хүдэр Засаг даргын Тамгын газар	Г.Дорждэрэм	45	45	42				93.3
115	Цагааннуур сумын Засаг дарга	Г.Дорждэрэм	48	48	48				100.0
116	Цагааннуур сумын Хоршоо хөгжүүлэх сан	Г.Дорждэрэм	42	42	42				100.0
117	Цагааннуур сумын Орон нутгийн хөгжлийн сан	Г.Дорждэрэм	42	42	42				100.0
118	Цагааннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Г.Дорждэрэм	45	45	45				100.0
119	Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газар	Г.Дорждэрэм	45	45	45				100.0
120	Шаамар сумын Засаг дарга	Г.Дорждэрэм	48	48	37	8	3		77.1
121	Шаамар сумын Хоршоо хөгжүүлэх сан	Г.Дорждэрэм	42	42	39	3			92.9
122	Шаамар сумын Орон нутгийн хөгжлийн сан	Г.Дорждэрэм	42	42	42				100.0
123	Шаамар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	Г.Дорждэрэм	45	45	45				100.0
124	Шаамар сумын Засаг даргын Тамгын газар	Г.Дорждэрэм	45	45	43	2			95.6
125	Шаамар сумын Дулаанхаан тосгоны Захирагчийн алба	Г.Дорждэрэм	45	45	40	3	1		88.9
126	Хушаат дуут хад ААТҮГ	Г.Дорждэрэм	46	46	43		1		93.5
127	Хүдэр тохижилт ОНӨААТҮГ	Г.Дорждэрэм	46	46	44	2			95.7
128	Илдэнбүрэн ААТҮГ	Г.Дорждэрэм	39	39	39				100.0
	Дүн		5653	5566	5470	96	19	87	96.8

оОо

**ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙГ ХУГАЦАА ХОЦРООЖ
МЭДЭЭЛСЭН БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**



Байгууллагын тоо	Мэдээллийн тоо	Мэдээ, тайлангийн төрөл	Мэдээлэх сар	Хянасан тэмдэглэгээ
СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА				
https://shilendans.gov.mn/organization/5462?ry=2025&group=6				
1	1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл	2	Хугацаа хоцорсон мэдээлэл
	2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	1	Хугацаа хоцорсон мэдээлэл
СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР				
https://shilendans.gov.mn/organization/5462?ry=2025&group=117				
2	3	Байгууллагын батлагдсан төсөв	1	Хугацаа хоцорсон мэдээлэл
СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ				
https://shilendans.gov.mn/organization/21275?ry=2026&group=1				
3	4	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	1	Хугацаа хоцорсон мэдээлэл
	5	Санхүүгийн тайлан	1	Хугацаа хоцорсон мэдээлэл
	6	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	1	Хугацаа хоцорсон мэдээлэл
СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ				
https://shilendans.gov.mn/organization/21364?ry=2025&group=117				
4	7	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал	1	Хугацаа хоцорсон мэдээлэл
